



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253.

Цахим шуудан: [uvurkhangai@audit.gov.mn](mailto:uvurkhangai@audit.gov.mn),  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2023. 04. 18 № 205

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит нөхөн сонгуульд оролцох Иргэдийн оролцооны нэгдэл намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2023 оны ээлжит нөхөн сонгуульд оролцох аймгийн Иргэдийн оролцооны нэгдэл нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит нөхөн сонгуульд оролцох Иргэдийн оролцооны нэгдэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030784

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## Дүгнэлт

Иргэдийн оролцооны нэгдэл намын "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит нөхөн сонгууль"-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэдийн оролцооны нэгдэл намын мөрийн хөтөлбөр / 2 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

**2023 ОНЫ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД  
ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМААС ДЭВШҮҮЛСЭН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Нэг. Орон нутгийн нийгэм эдийн засгийн ерөнхий асуудлаар**

- 1.1. Орон нутагт бизнес эрхлэхэд таатай орчин бүрдэж чадсан эсэхийг иргэдийн нээлттэй сонсголоор хэлэлцүүлнэ.
- 1.2. Орон нутгийн иргэд бүс нутгийн эдийн засаг, мэргэжлийн холбоодыг хэрхэн байгуулж ажиллах талаар иргэдээс санал авч хэлэлцүүлэг өрнүүлнэ, бизнесийн орчныг ойлгомжтой нээлттэй байлгах, олон улсын жишигт нийцсэн орон нутгийн холбоодтойгоор ажиллах соёлыг дэлгэрүүлнэ.
- 1.3. Бага өртгөөр мод тарих, бэлчээрийг усжуулах, цөлжилтөөс хамгаалах талаар иргэдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх ажил өрнүүлнэ.
- 1.4. Хог хаягдлын менежментийн талаар олон нийтийг мэдлэгжүүлж Орон нутгийн зүгээс хэрэгжүүлж авч байгаа үйл ажиллагааг ил тод байлгах шаардлага тавина.
- 1.5. Жорлонг өөрчлөх талаар цуврал сургалт зохион байгуулна.

**Хоёр. Иргэдийн мэдэх эрхийн талаар**

- 2.1. Аймагт эрх барьж буй нам, засаг захиргааны үйл ажиллагаанд хяналт тавьж олон нийтэд нээлттэй мэдээлж иргэдийн мэдэх эрхийг хангахад үйлчилж ажиллана.
- 2.2. "Сөрөг хүчний төлөөлөл мэдээлж байна" сэдвээр хэвлэлийн бага хурал хийж, сөрөг хүчний хяналтыг хэрэгжүүлнэ.
- 2.3. Аймгийн төсвийн задаргааг олон нийтэд нээлттэй тайлбарлана.
- 2.4. Аймгийн худалдан авах гэрээнүүдийг ил тод байлгахыг шаардаж ажиллана.
- 2.5. Аймгийн газар, ховор ан амьтан, шувуу зэрэг ан агнуур, бизнесийн лиценз зөвшөөрлүүдийг ил тод болгоно.
- 2.6. Авилгын эсрэг хуулийн дагуу олон нийтийн хяналтад байх ёстой аймгийн албан тушаалтны нэрсийн жагсаалтыг ил байлгана.
- 2.7. Аймгийн бүх хэвлэлүүдэд хаалтын гэрээгүй ажиллахыг сануулсан уриалга хүргүүлнэ. Хаалтын гэрээ бол авилгачдад үйлчилж буй хэрэг бөгөөд иргэдийн мэдэх эрхийг боогдуулсан үйл болохыг уйгагүй сануулна. Үр дүнд нь сонгодог утгаараа иргэддээ үйлчилж чаддаг чөлөөт хэвлэлтэй аймаг болно.
- 2.8. Газар олголт, газрыг хэрхэн өмчлөх, эзэмших үйл явцыг ил тод болгох шаардлагыг хүргүүлж ажиллана.
- 2.9. Агаарын бохирдлыг бууруулахад зарцуулсан улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтыг ил тод болгох, иргэдэд мэдээлэл, хөрөнгийн зарцуулалтыг оновчтой болгох шаардлага тавьж, олон нийтийн хяналтыг сайжруулж ажиллана. Агаарын бохирдлыг бууруулах зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг Монгол гэрийн дулаалгын төслийг дэмжихэд чиглүүлнэ.
- 2.10. Авлигыг хэрхэн мэдээлэх, тэмцэх талаар мэдээллийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах



*Handwritten signature and initials.*

### Гурав. Төсвийн асуудлаар

- 3.1. Хямд өртгөөр, иргэдийн оролцоотойгоор хийж болох аливаа ажлыг хэт их мөнгөөр цөөхөн хүний гарт баялаг төвлөрүүлэх замаар хийлгэхгүй байхад анхаарна.
- 3.2. Монголын нөхцөлд дор хаяж 24 сарын турш амжилттай ажиллаагүй бол аливаа шинэ, эрсдэлтэй технологид төсвийн хөрөнгө оруулалтын мөнгийг зарцуулахгүй гэсэн байр суурь баримтална.
- 3.3. Орон нутгийн иргэдээс авч болох худалдан авалтыг дэмжинэ.
- 3.4. Иргэдээс санал авч дэмжигдсэн хөрөнгө оруулалтад эхний ээлжийн хуваарилалт хийх бодлого баримтална.
- 3.5. Нийтийг гамшгаас хамгаалах зориулалттай аливаа байгууламжийг байгуулах, сэргээх болон эвдэж өөрчлөхгүй байхад анхаарна.
- 3.6. Ашиглалтын зардал өндөртэй байгууламжид төсвийн хөрөнгө оруулалтыг хийлгэхгүй байх, эсвэл багасгах бодлого баримтална.
- 3.7. Аймагтаа ногоон стандартын барилга байгууламжийг нэмэгдүүлэх, ашиглалтын зардал багатай ухаалаг хөрөнгө оруулалт оруулж ирэхийг дэмжинэ.

Жич: Манай намын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шинээр төсөвт хөрөнгө оруулалт шаардагдахгүй, харин төсвөөс хэмнэлт хийхэд чиглэгдсэн болно.

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН ӨВӨРХАНГАЙ  
АЙМГИЙН ТАНХИМЫН

ДАРГА *Б.Ууганбаяр* Б.УУГАНБАЯР



*Handwritten signature*



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2023. 04. 18 № 208

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох Иргэний оролцооны нэгдэл намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох Иргэний оролцооны нэгдэл нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана. Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулаагүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох Иргэний оролцооны нэгдэл намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

015030003


D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## Дүгнэлт

Иргэний оролцооны нэгдэл нам нь нөхөн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд хүлээн авсан хандивын орлогыг бүртгэж тайлагнасан байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



О.БАТЖАРГАЛ